



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/13

Бор-Өндөр сум

Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний
зардлаас хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.15, 16.5.5 дахь хэсгийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын Уурхайчин 4 дүгээр багт байрлах хүүхдийн тоглоомын талбайн сагсны шийдийг хашаажуулах ажилд урьдчилгаа 70 хувийн санхүүжилт болох 7,716,520 (долоон сая долоон зуун арван зургаан мянга таван зуун хорь) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 7,716,520 (долоон сая долоон зуун арван зургаан мянга таван зуун хорь) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас зохих хууль дүрэм, журмын дагуу хяналт тавьж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ